



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М. ГАНБААТАР



Тоноглолын
Ашиглалтын болон
Засварын ажилтны
Аюулгүй
ажиллагааны
ерөнхий
зааварчилгаа

ТТТ-ТЭ-01


Хувилбар: 1

Тушаал № 7742



ТОНОГЛОЛЫН АШИГЛАЛТЫН БОЛОН ЗАСВАРЫН АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01	БАТЛАВ Гүйцэтгэх захирал /...../ М. Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

ТОНОГЛОЛЫН АШИГЛАЛТЫН БОЛОН ЗАСВАРЫН АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагаа	4
Хоёр. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	5
Гурав. Осол, аварь, гамшгийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	6
Дөрөв. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага	7

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

НЭГ. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- 1.1. Ажилтан ажлын цаг эхлэхээс өмнө 30 минутын өмнө ирж ажлын тусгай хувцас, гутлыг өмсөж, хувийн хамгаалах хэрэгслийг бэлдсэн байна. Халаасанд ажлын бус зүйл байгаа эсэхийг шалгана. Ханцуйвч, өмд заавал товчлогдсон, үс малгайн дотор бүрэн орсон байна.
- 1.2. Ажлын байранд хувцас солихыг хориглоно.
- 1.3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын, засварын ажилтан болон хөдөлгөөнт механизм бүр радио станцаар тоноглогдсон, хангагдсан байх. Радио станц ашиглагч нь түүний бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хариуцна.
- 1.4. Ажлын байрны үзлэг хийж өөрт болон бусдад аюул, эрсдэл учруулж болох нөхцөл байдал илэрвэл ажлыг эхлүүлэхийг хориглох бөгөөд шууд харъялах албан тушаалтанд мэдэгдэж аюулыг арилгах, эрсдлийн төвшинг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- 1.5. Ээлж хүлээлцэх үед мөрдөх аюулгүй ажиллагааны:
 - ❖ Ажлын тусгай хувцас, гутал хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн зөв өмсөж хэрэглэсэн байна;
 - ❖ Радио станц, шаардлагатай багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг шалгана;
 - ❖ Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл (гэрэлтүүлэг, агааржуулалт, шалны гадаргуу г.м.) хэвийн эсэхийг шалгана;
 - ❖ Багаж хэрэгсэл, хэрэгцээт бусад зүйлс бэлэн байгаа эсэхийг шалгах;
 - ❖ Анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл, гал унтраах багаж зэвсэглэл хэвийн ажиллагаатай, хангалттай байгаа эсэхийг шалгана;
 - ❖ Өмнөх ээлжинд гарсан аюултай тохиолдол, осол аваарь, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, аюулгүй ажиллагаа зөрчигдсөн тохиолдлын талаар мэдээлэл авч ажил гүйцэтгэх хугацаанд давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна;
- 1.6. Тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө дараах зүйлсийг шалгасан байна:
 - ❖ Цахилгаан тоноглолуудын удирдлага залгах, салгах аваарын унтраалга, цахилгааны шитэнд хүрэхэд ямар нэгэн саадгүй чөлөөтэй байгаа эсэх;
 - ❖ Дуут болон гэрлэн дохио хэвийн эсэх;
 - ❖ Газардуулга, түүний бүрэн бүтэн эсэх;
 - ❖ Бүх хэсэг, холбогчийн эрэг боолтууд хэвийн байгаа эсэх;

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

- ❖ Тос масло хангалттай байгаа эсэх;
 - ❖ Хамгаалах хаалт, бусад хэрэгслүүд хэвийн байгаа эсэх;
 - ❖ Цахилгаан дамжуулах шугам, удирдлагын самбарт ил гэмтэл байгаа эсэх;
 - ❖ Ачаа өргөх механизм, татан авах хэрэгслийн ажиллагаа хэвийн эсэх;
- 1.7. Ахлах ажилтан (ажил удирдагч, ээлжийн ахлах)-аас тухайн өдөр (ээлж)-ийн гүйцэтгэх ажлыг аюулгүй гүйцэтгэх, ажлын байрны нөхцөлд тохирсон өдөр тутмын зааварчилгааг аман болон бичгээр авч танилцаж бүрэн ойлгосны үндсэн дээр ажлыг аюулгүй гүйцэтгэхээ баталгаажуулж гарын үсэг зурсан байна.
- 1.8. Ажлын байрны үзлэг хийж аюул эрсдэлийг илрүүлж арилгах, өөрийн ажлын чиг үүрэгт нийцэхгүй зүйлсийг арилгуулна. Ажилтан аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа ажил эхлүүлэх үүрэгтэй.

ХОЁР. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ

АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- 2.1. Ажилтан ажлын байранд ажлын тусгай хувцас, гутал, хамгаалах хэрэгслийг зөв бүрэн хэрэглэж тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалын технологи, зориулалтын дагуу ашиглалтын заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөж ажлыг үр дүнтэй гүйцэтгэх үүрэгтэй.
- 2.2. Ажилтан зөвхөн удирдлагаас өгсөн наряд, үүрэг даалгавар, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгэнэ.
- 2.3. Өндөр эрсдэлтэй ажлын байранд нэг ажилтан ажиллуулахыг хориглоно.
- 2.4. Технологийн дамжлагын тоног төхөөрөмжүүдийг ажиллагааны схем (зураг), горимын дагуу дэс дараатайгаар ажиллуулж зогсооно. Дамжлагын тоног төхөөрөмжүүдийг ажиллуулалж эхлэхийн өмнө станцаар болон биечлэн мэдэгдэнэ.
- 2.5. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, механизмын хөдлөж байгаа хэсгүүдэд гар, хувцас, бусад зүйлээр хүрэх болон хүрэлцэхийг хориглоно.
- 2.6. Ажил гүйцэтгэхдээ анхаарал болгоомжтой ажиллах бөгөөд бусад анхаарал сарниулах гар утас, тоглоом зэрэг эд зүйл ашиглах, бусадтай ярих, анхаарлыг нь сарниулахыг хориглоно.
- 2.7. Шатах шингэн болон хөнгөн зуурамтгай шингэнийг зориулалтын бус сав, хаяг шошгогүй хадгалах, ил задгай эзэнгүй орхихыг хориглоно.
- 2.8. Эзэнгүй орхисон болон хаяг шошгогүй шингэн материалд дур мэдэн хүрэхийг хориглоно. Дээрх зүйлсийг олж харсан ажилтан ахлах ажилтан буюу ажил удирдагчид мэдээлэх үүрэгтэй.

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

- 2.9. Ажилтан хий, кабель халсан, шатсан үнэр үнэртсэн, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гал гарсан, гэмтэл гарсан зэрэг аюултай байдлыг олж харсан даруйд цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдлийг салгаж, ажлаа зогсоож ахлах ажилтанд мэдэгдэнэ.
- 2.10. Ажилтан ажил гүйцэтгэх хугацаанд ажлын байрыг орхих, хуваарийн дагуу завсарлага авах, хоолонд орох бүртээ ахлах ажилтан буюу ажил удирдагчид мэдэгдэж зөвшөөрөл авна. Ажлын байрыг дур мэдэн орхихыг хориглоно.
- 2.11. Хоол хүнсийг зөвхөн зориулалтын байр, цайны газарт хэрэглэнэ. Цай хоолонд орохын өмнө гараа савандаж угаана.
- 2.12. Ашиглах боломжгүй болсон хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, бараа материалыг ахлах ажилтан буюу ажил удирдагч, холбогдох бусад албан тушаалтанд мэдэгдэж засварлуулах, актлаж шаардлага хангасан шинэ зүйлээр солиулах.
- 2.13. Ажиллаж байгаа тоног төхөөрөмжид засвар, цэвэрлэгээ, үйлчилгээ хийхийг хориглох бөгөөд 1.5 метрээс бага зайд ойртохыг хориглоно.
- 2.14. Цахилгаан тоног төхөөрөмжид засвар, цэвэрлэгээ, үйлчилгээ хийхийн өмнө цахилгаан тэжээлийн залгуурыг бүрэн салгаж “Асааж болохгүй – хүмүүс ажиллаж байна” плакат, анхааруулах тэмдэг байрлуулсан байна.
- 2.15. Бусдын өлгөсөн, байрлуулсан плакат, аюулгүй ажиллагааны анхааруулах болон хориглох тэмдэг, ажил зогсоосон актыг авахыг хориглох бөгөөд дээрх зүйлс байрлуулсан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн удирдлагын самбарт ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 2.16. Ажилтан тоног төхөөрөмжийн болон бусад төрлийн хаалт, хашилт, хамгаалалт, бүтээлэг зэргийг авах, налах, дээр нь суухыг хориглоно.

ГУРАВ. ОСОЛ, АВААРЬ, ГАМШГИЙН ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- 2.17. Ажилтан биеийн байдал муудсан, бэртэж гэмтсэн, осолд өртсөн болон осолд өртсөн хүнийг харсан тохиолдолд ахлах ажилтан буюу ажил удирдагчид болон холбогдох албан тушаалтанд нэн даруй мэдэгдэж ослын үед ажиллах зааварчилгааг мөрдөж анхны тусламж үзүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй.
- 2.18. Ажилтан осол, аварь, гал гарсан болон гамшгийн үед шууд удирдлага болон холбогдох албан тушаалтанд мэдэгдэж эргэн тойрны хүмүүсийг аюулаас сэргийлэхийг анхааруулж, гал асах, утаа гарч байгаа хэсэг, нуралт үүсэх

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

магадлалтай газруудаас боломжийн хэрээр хүмүүсийг гаргаж, аюулгүй газарт хүргэх үүрэгтэй бөгөөд эд зүйлсийг боломжийн хэрээр гаргах, галыг унтраах арга хэмжээ авна.

2.19. Осолд өртсөн хүнд тусламж үзүүлэх:

- ❖ Гэмтээгч хүчин зүйлийн нөлөөллөөс салгах арга хэмжээ авах;
- ❖ Анхан шатны тусламж үзүүлэх;
- ❖ Удирдлагад мэдээлэх;
- ❖ Шаардлагатай тохиолдолд түргэн тусламжийн баг дуудах, эмнэлэгт хүргэх;

2.20. Хэрэв осол гарсан газар нь бусдыг гэмтээхээргүй бол хэвээр үлдээх.

2.21. Онцгой байдлын баг ирэхэд гамшиг осол, галын хэмжээ, авсан арга хэмжээний талаар шаардлагатай мэдээлэл өгнө.

ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 4.1. Ажил гүйцэтгэхэд ашиглагдсан цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цахилгаан гүйдлээс салгаж, бүрэн зогссоныг шалгана.
- 4.2. Ашигласан багаж хэрэгсэл, бараа материалын үлдэгдлийг зориулалтын газар хураана.
- 4.3. Ажилтан ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, зааврын дагуу ажлын байрыг цэгцлэн цэвэрлэх үүрэгтэй.
- 4.4. Ажилтан дараагийн ээлжийн ажилтантай хамт ажлын байрны үзлэгийг чанартай сайн хийж акт үйлдэж, ажил гүйцэтгэх шаардлагатай тоног төхөөрөмж, механизм, багаж хэрэгслийг бүрэн бүтэн, хэвийн үйл ажиллагаатай хүлээлгэн өгнө.
- 4.5. Хэрэв зөвхөн тоног төхөөрөмжийг ажиллагаатай байдлаар дараагийн ээлжийн ажилтанд хүлээлгэж өгөх шаардлагатай үед шууд удирдлага (ээлжийн ахлах эсвэл ашиглалтын инеженер)-ыг ээлж хүлээлцэх (тоног төхөөрөмж хүлээлцэх)-д заавал байлцуулна.
- 4.6. Ажлын тусгай хамгаалалтын хувцас хэрэгслийг тайлж зориулалтын шкаф, саванд хийж хадгалах, дахин ашиглах боломжгүй хамгаалах хэрэгсэл, бараа материалын хаягдлыг зориулалтын хогийн саванд хийх.
- 4.7. Ажилтан ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан, тухайн ээлжинд арилгах боломжгүй үлдсэн, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүрэн гүйцэт хэрэгжүүлж дуусаагүй аюул, эрсдлийн тухай үнэн бодит мэдээллийг дараагийн ээлжин ажилтанд мэдээллэж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-ТЕ-01
	Хувилбар: 1

- 4.8. Ахлах ажилтан буюу ажлын удирдагчийн ажлын байрыг орхих зөвшөөрөл авсны дараа ажлын байрыг орхиж ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг тайлж зориулалтын шкаф, саванд хийж хадгална.
- 4.9. Бохирдсон ажлын тусгай хувцсыг угаалганд өгнө.
- 4.10. Дахин ашиглах боломжгүй болсон ашиглалтын хугацаа дуусаагүй ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэж актлан шинээр солиулна.
- 4.11. Савантай бүлээн усаар биеийн бүх хэсгийн угааж, шүршүүрт орно.
- 4.12. Хувийн хувцас, гутлыг өмсөж, үйлдвэрийн бүсийг чөлөөлнө.